



**“ХХХМС-2 ПРОГРАММЫН ДЭД БААЗЫН БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛТ  
ХИЙХ БА ГЯЛС СИСТЕМТЭЙ ХОЛБОХ АЖИЛ” ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: **ХХХМС-2** программын дэд баазын бүртгэлд өөрчлөлт,  
шинэчлэлт хийх ба гялс системтэй холбох ажил

Тендерийн дугаар: **ХА-010/2020**

*Улаанбаатар хот - 2020 он*

## ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

Тендерийн нэр: **XXXМС-2 программын дэд баазын бүртгэлд өөрчлөлт, шинэчлэлт хийх ба гялс системтэй холбох ажил**

Тендерийн дугаар: **ХА-010/2020**

**“УБЦТС” ТӨХК** эрх бүхий тендерт оролцогчдоос **“XXXМС-2 программын дэд баазын бүртгэлд өөрчлөлт, шинэчлэлт хийх ба гялс системтэй холбох ажил”** гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50,000 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг **2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 09 цаг 00 минутаас** өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 09 цаг 15 минутад** тендерийн нээлтийн өрөөнд нээнэ. /УБЦТС ТӨХК-н төв байрны 206 тоот/

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Захиалагчийн хаяг:**

**Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг. 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө-45.**

**УБЦТС ТӨХК-ийн төв байр. 206 тоот. Хангамж үйлчилгээний алба**

**Утас: 342420 +157, Факс: 976-341852**

**Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.

- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<p><b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b></p>	<p align="center"><b>Шалгуур үзүүлэлт</b></p>
<p><b>ТӨӨЗ 1.1</b></p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн хоёр жил буюу 2018, 2019 оны санхүүгийн аудитлагдсан тайлан аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ</li> <li>2. Сүүлийн 2 жил буюу 2018,2019 оны жил тус бүрийн борлуулалтын орлого санал болгож буй үнийн дүнтэй дүйцэцүйц байна.</li> <li>3. Сүүлийн хоёр жил буюу 2018, 2019 оны аль нэг жилд ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлнэ.Ижил төстэй ажлын өртөг жил тус бүрийн аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх /Ижил төстэй ажилд програм хангамжийн ажил гэрээгээр гүйцэтгэсэн байна. Ажлын гэрээний хуулбар, гүйцэтгэлийн акт ирүүлнэ.Нотлох бичиг баримтыг хавсарган ирүүлэх/ <b><u>Нэмэлт шаардлага</u></b></li> <li>4. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга</li> <li>5. Улсын бүртгэлийн гэрчилгээ, үйл ажиллагааны чиглэл: Програм хангамж байх</li> <li>6. Үнийн саналыг маягтын дагуу ирүүлэх. Төсөвт өртөг: <b>49,500,000</b> төгрөг</li> <li>7. Ажил гүйцэтгэлийн төлөвлөгөөг ажлын даалгаварт үндэслэн нарийвчлан гаргаж ирүүлэх.</li> <li>8. ШШГЕГ-ын тодорхойлолт</li> <li>9. Татварын тодорхойлолт /тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байна./</li> <li>10. Гэрээний үнэ, хугацаанд хийж гүйцэтгэж, хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл ирүүлнэ.</li> <li>11. Ажлыг гүйцэтгэх мэргэжилтэй инженер техникийн ажилчид доорхи шаардлагыг хангасан байна.             <ul style="list-style-type: none"> <li>- Төслийн удирдагч-1 /Мэдээллийн технологийн чиглэлийн мэргэжилтэй, мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан туршлагатай байх, хөгжүүлж байсан систем нь тухайн байгууллагынхаа бизнес процессоо удирддаг байх, удирдаж байсан төслүүд нь амжилттай хэрэгжсэн байх, тухайн байгууллагынхаа үндсэн ажилтан байх/</li> <li>- Систем хөгжүүлэгч -2 /Мэдээллийн технологийн чиглэлийн мэргэжилтэй,програм хангамжийн чиглэлээр ажил гүйцэтгэж байсан байна./</li> <li>- ХХХМСистемийн хөгжүүлэлтэд оролцож байсан компани болон хөгжүүлэлт хийж гүйцэтгэж байсан програмист инженертэй бол давуу тал болно.Нотлох баримтууд ирүүлнэ.</li> </ul> </li> <li>12. Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ.</li> <li>13. Чанарын баталгаат хугацаа <b>12</b> сар</li> </ol>

<p><b>ТӨӨЗ 2.1</b></p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p><b>Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д өөрийн аж ахуйн нэгжийн хувийн нууцлалын кодоор нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ. Харилцах утас: 976-11-342420+157, 158</b></p> <p>Огноо: <b>2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>09 цаг 00 минут</b></p> <p><b>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</b></p>
<p><b>ТӨӨЗ 2.1</b></p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байшин, гудамжны нэр: <b>3-р хороо Чингисийн өргөн чөлөө-45, "УБЦТС" ТӨХК-ийн төв байр.</b></p> <p>Давхар болон ерөөний дугаар <b>2-р давхар, 206 тоот өрөө.</b></p> <p>Аймаг, хот: <b>Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг</b></p> <p>Улс: <b>Монгол Улс</b></p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:</p> <p>Огноо: <b>2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>09 цаг 15 минут</b></p>
<p><b>ТӨӨЗ 6.1</b></p>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>Багцгүй</b></p> <p><b>“ХХХМС-2 программын дэд баазын бүртгэлд өөрчлөлт, шинэчлэлт хийх ба гялс системтэй холбох ажил”</b></p>
<p><b>ТӨӨЗ 7.1</b></p>	<p>Шалгарсан тендерт оролцогч нь гэрээтэй уншиж танилцан гарын үсэг зуран баталгаажуулж ажлын 6 хоногийн дотор Захиалагчид хүргүүлнэ.</p>

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### Техникийн тодорхойлолтыг бэлтгэх санамж

Товч бөгөөд тодорхой бэлтгэгдсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендер оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно.

Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ өрсөлдөөнийг аль болох өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд үүний зэрэгцээ худалдан авах бараа, ажил, үйлчилгээний шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгана.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн, эсхүл орчин үеийн загварын, зураг төсөл, материалын хувьд сүүлийн үеийн хандлагыг хангасан байх нөхцөлийг техникийн тодорхойлолтод шаардах ёстой.

Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай байдаг. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ метрийн системийг ашиглана. Бүх салбарт хэрэглэж болох нийтлэг жишиг техникийн тодорхойлолт гэж байхгүй. Бүх төрлийн бараа, ажлын стандарт буюу ерөнхий техникийн тодорхойлолт боловсруулж стандартчилах нь чухал ач холбогдолтой. Энэ стандарт техникийн тодорхойлолтыг тухайн ижил бараанд нийцүүлэн, зохих өөрчлөлт оруулах замаар ашиглана.

Авто зам, усан зогсоол, төмөр зам, орон сууц, усжуулалт, усан хангамж гэх зэрэг дэд бүтцийн салбаруудад тухайн бүс нутгийн ижил төстэй нөхцөлд давтагдаж хийгдэх ажлуудад стандарт ерөнхий техникийн тодорхойлолтыг хэрэглэх нь ихээхэн давуу талтай. Хэдийгээр тухайлсан ажлын гэрээнд заавал хэрэглэх шаардлагагүй хэдий ч барилгын ажилд хамаарах онцлог шинж чанар, материал, тоног төхөөрөмжийн бүх ангиллыг ерөнхий техникийн тодорхойлолтод тусгах шаардлагатай. Тухайн ажлын техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ ерөнхий техникийн тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт хийх буюу шаардлагагүй зүйлийг түүнээс хасна.

Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Бараа, материал, шинж чанарын талаарх техникийн тодорхойлолтын стандартад аль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа, материал, шинж чанар нь энэ стандартыг хангах буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй. Дараах заалтыг гэрээний тусгай нөхцөлд, эсхүл техникийн тодорхойлолтод тусгаж болно.

#### **Жишиг заалт: Стандарт болон кодын дүйцэх байдал**

Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал болон хийгдэх, эсхүл турших ажлын стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлноор хэрэглэнэ.

Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй жишихүйц, эсхүл түүнээс илүү чанартай бусад стандарт, кодыг төслийн менежер хянаж, бичгээр зөвшөөрөл олгосон бол хүлээн зөвшөөрнө.

*Техникийн тодорхойлолтыг бэлтгэхэд зориулсан эдгээр санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно.*

*Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулах шаардлагагүй.*

**ХХХМСИСТЕМИЙН ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОЛОН ТООЛУУРЫН ДЭД  
СИСТЕМД /TECH SERVICE, INDICATOR/ ХИЙГДЭХ НЭМЭЛТ САЙЖРУУЛАЛТ,  
ХӨГЖҮҮЛЭЛТИЙГ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР**

**ЗОРИЛГО:**

УБЦТС ХК-ийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй Хэрэглэгчтэй Харилцах Харилцааны Менежментийн Системийн нэмэлт сайжруулалт, хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэх.

**ХАМРАХ ХҮРЭЭ:**

УБЦТС ХК-ийн Тоолуур хэмжих хэрэгслийн хэлтэс, ХҮТ-үүдийн ТҮХ, ТТҮХ-үүд болон Цахилгаан эрчим хүч хэрэглэгч ахуйн болон аж ахуй нэгж байгууллага хамаарна.

**ҮР ДҮН:**

ХХХМСистемийн Техник үйлчилгээний дэд програм хангамж ХҮТ-ийн нэгжүүд болон Төвийн хэсгийн хэлтэс, нэгжүүдийн мэдээлэл солилцох болон ажлын уялдаа холбоо сайжирч, мэдээллийг харах, боловсруулах, хяналт тавихад хялбар болно.

**ПРОГРАМЫН БҮРДЭЛ ХЭСЭГ:**

ХХХМСистем нь 6 дэд програмуудтай бөгөөд өөр хоорондоо уялдаа холбоо бүхий нэгдсэн мэдээллийн баазтай систем юм.

*Техник үйлчилгээний программ /Хавсралт №1/*

- ✓ Хэрэглэгчийн ЦЭХ-ний таслалт, залгалт, дуудлагатай холбоотой үйл ажиллагааны процесст орсон өөрчлөлтийн дагуу програмд оролт, гаралт, процедур, мэдээллийн сангийн болон програмын шаардлагатай өөрчлөлтүүдийг хийж гүйцэтгэх
- ✓ Шинээр нэмэгдэх үйлдэл процессийг даалгаврын дагуу нэмэлт модуль, форумуудыг хийж гүйцэтгэх
- ✓ Одоогийн гарч байгаа тайлангийн өөрчлөлт болон нэмэлт тайланг загварын дагуу хийж гүйцэтгэх

*Тоолуурын програм /Хавсралт №2/*

- ✓ Хэрэглэгчийн тоолуур хэмжих хэрэгсэл түүнтэй холбоотой үйл ажиллагааны процесст орсон өөрчлөлтийн дагуу програмд оролт, гаралт, процедур, мэдээллийн сангийн болон програмын шаардлагатай өөрчлөлтүүдийг хийж гүйцэтгэх
- ✓ Шинээр нэмэгдэх үйлдэл процессийг даалгаврын дагуу нэмэлт модуль, форумуудыг хийж гүйцэтгэх
- ✓ Одоогийн гарч байгаа тайлангийн өөрчлөлт болон нэмэлт тайланг загварын дагуу хийж гүйцэтгэх



## Техник үйлчилгээний програм

- ❖ Програмд шинээр хийгдэх болон одоогийн байгаа процессд хийгдэх нэмэлт сайжруулалт өөрчлөлтүүд:

1. ХХХМС систем болон ГЯЛС системүүдийн шаардлагатай хэсгүүдийг хоорондоо холбогдон ажилладаг боломжтой болгох. Хоорондоо шилжиж байгаа ажлууд нь 2 талдаа архивлагдан харагддаг байх. Дараахи ажлууд:

- Бүх төрлийн үзлэгийн ажлын мэдээллүүд /гэмтэл гарсан цэгийн байршил үндсэн мэдээлэл фото зураг, бусад/ ГЯЛС /гар утас QR код ашиглан/ дамжин ХХХМС-т бүртгэгддэг байх. Үүнд бусад нэгжүүдээс ирж байгаа гэмтэл зөрчлийн мэдээллүүдийг ГЯЛС болон ДМСС программудыг ашиглан мөн бусад байдлаар ирүүлэх боломжтой болгох. Мөн ТҮХ ИТА гараар нэмж оруулах боломжтой цэстэй болгох.
- Үзлэг зөрчил гэмтлийн мөрөөр ажлын захиалгаар хийсэн ажлын гүйцэтгэлийн мэдээллийг оруулахдаа мөн ГЯЛС ашиглан ХХХМС-т бүртгэх. Хугацааны болон ажилбарын төрлөөр одоо гэмтэлтэй байгаа ажлуудын болон гүйцэтгэл орсон ажлын тайлан гардаг байхаар бэлтгэх.

1. Алдааны код нэмэлт ажил тайлбарууд оруулах боломжтой болгон сайжруулалтууд хийх, БХ-ээс илгээгдэж байгаа алдааны кодоор орж ирсэн мэдээлэл дээр дэд станц, щитний дугаараар гаргадаг болгох

Алдааний кодоор хийгдсэн ажлын тайлан гардаг болгох. Тайланд фидер, станц, щит, хэрэглэгчийн код, алдааны код илгээсэн ажилтны код, ажлын тайлбар, зөрчлийг арилгасан ажилтны нэр, гүйцэтгэлийн тайлбар бүрэн гардаг байх. Алдааний кодны төлөв цэсэнд байгаа тайлбарыг бүрэн гаргадаг болгох.

ТУГУБ-н алдааны мэдээлэл экспортлохгүйгээр тайлан болон нэг нэгээр нь хэвлэгддэг болгох

2. Шинэ холболтын жагсаалтанд тодруулга хийсэн ажилтны нэр програмд харагддаггүй, сис ажилтан цэснээс сонгосон ажилтан харагддаг. Ажилтан цэснээс сонгосон ажилтны нэрийг А.Ажилтан баганын ард багана нэмж оруулж өгөх.

3. Хэрэглэгчийн мэдээллийн түүхэнд щит эвдсэн болон бусад зөрчил гаргасан тухай бүртгэгддэг болгох

4. Тогтмол мэдээллийн дэд станцаас тэжээгдэж буй хэрэглэгчийн түүхийн цэсэнд сайжруулалт хийх

ХХАТ болон ТХ-с хэрэглэгчийн мэдээлэл өөрчлөх тоолуур солих, лац солих, шинээр код гаргах хэрэглэгчийн хаяг утас өөрчлөгдөх зэрэг ажилбар үүсгэхэд ТҮХ-н Дэд станцын тр-с тэжээгдэж байгаа хэрэглэгчийн жагсаалтанд тодорхой биш хэрэглэгчийн жагсаалт руу үүсгэгддэг. Сар бүр баланс гаргахад бүх хэрэглэгчийг тодорхой төлөв рүү шилжүүлж өгөх шаардлага гардаг. Тухайн тодорхой биш хэрэглэгчийг хайхад хүндрэлтэй бүх фидер станцаар түүж ордог.

5. Шинэ холболтийн тодруулга товчоо /ГХ.ОС.ААН ЗУСЛАН/ гэж ангилж оруулах
6. Гялс програмаар үүсгэсэн төлбөрт үйлчилгээний төлбөр АБХ-ийн тайлан дээр гардаг, мөнгөн дүнгээрээ гялс програм дээрх төлбөрт үйлчилгээний тайлангийн мөнгөн дүнтэй таарахгүй байгааг засах.
7. 35кВ-ийн дэд станцууд нь дугаар байхгүй нэрээрээ байдаг нь засвар хийх /уртраг, өргөрөг/ оруулах боломжгүй, шинээр бүртгэх боломжгүй байгааг засварлах
8. Холболтын цэгийн мэдээлэл дээр хэрэглэгчийн хүчдэлийн түвшинг засаж болдог болгох.
9. Холболтын цэгийн мэдээллийн тайлбар хэсэгт тайлбар бичиж харуулдаг болгох.
10. Шинэ холболтын ажлын захиалга хийгдсэн болон буцаасан, гүйцэтгэх боломжгүй гэсэн ангилалаар техник үйлчилгээний дэд системд гардаг байх
11. Хэрэглэгчийн тоо зөрж байгааг засварлах/ Хэрэглэгчийн лавлагаа болон хэрэглэгчийн жагсаалтанд байгаа тооны зөрүүг ижил болгох/
12. Хэрэглэгчийн лавлагаа болон холболтын цэгийн мэдээлэлд тоолуурын дугаараар хайлт хийх боломжтой болгох.
13. Щитний бүхий л мэдээлэл харуулдаг болгох:  
Щитний мэдээлэл оруулах үед тухайн щитийг суурилуулсан огноо, багтаамж, газардуулга байгууламж, Ерөнхий автомат байгаа эсэхийг нэмж бүртгэх боломжтой болгох, Щитний байрлал /тулгуурт, эсвэл газарт/ хардаг эсэхийг сайжруулах.
14. Щитний гэрээний хугацаа дууссан хэрэглэгчийн гэрээ автоматаар цуцлагдаж төлбөр ордоггүй болгох
15. Щитний техникийн паспортын бичиг баримтуудыг ХХХМС-2 програмд батлагдсан загварын дагуу бүртгэдэг цэстэй болгох:  
Үүнд: Тухайн щитний бүхий л төрлийн мэдээллийг оруулдаг боломжтой, фото зураг оруулах боломжтой болгох. QR кодыг ашиглалтанд нэвтрүүлж кодын тусламжтайгаар мэдээллүүдийг бүртгэн ГЯЛС болон ХХХМС системүүдийг холбож ажиллагаанд оруулах мөн үндсэн мэдээллүүдийг бэлтгэгдсэн загварын дагуу бүртгэдэг, засварладаг болгох. Щитний графикт үзлэгээр илэрсэн гэмтэл согогийг бүртгэж оруулах, гэмтлийг устгасан тайлан гарч байх. Нэгдсэн щитэнд хийсэн бүхий л үзлэг урсгал засвар хийгдсэн ажлыг системд бүртгэж, засварын дүнг оруулж тайлан авдаг байх.
16. Ашиглалтын түвшин тогтоох үзлэг, үзлэгээр илэрсэн гэмтлийг бүртгэдэг, арилгасан гэмтлээ бүртгэдэг цэсийг боловсронгуй болгох, үүнтэй холбоотой хийгдсэн ажлын болон хугацааны тайланг ажил гүйцэтгэсэн ажилтан тус бүрээр гардаг болгох . Гар утасны программ ашиглан хийх
17. Урсгал засварын ажлын гүйцэтгэл бүртгэдэг болох цэстэй болгох. Цэсэнд шит бүрийг бүртгэсний дараа /Техникийн паспортын мэдээлэлтэй уялдаж/ техникийн ашиглалтын дүрмийн дагуу заагдсан хугацаа хүрмэгц автоматаар засвар хийгдэх шитнүүдийн жагсаалт ажлын захиалга болон гардаг байх. Тухайн щитэнд засвар хийсэн материал бүрээр бүртгэх/ урсгал засвар хийгдсэн болон тодорхой хугацаанд хийгдээгүй дэд станц, тоноглолын мэдээлэл “Статик” мэдээнээс ажилтны ажлын гүйцэтгэлийн тайлан тус тус гардаг байх. Жишээ нь: Тайланд товчоогоор фидер, станц АТП-1426 шит№1,,5, засвар орсон, мөн материалын төрлөөр засвар хийсэн ажлын гүйцэтгэл харагддаг байх.-АТП-1426-ын 25 шитэнд 30

- плакат хадсан, 40 шитэнд цоож хийсэн гэх мэт хийгдсэн ажилбар бүрээр гаргадаг болгох. Засвар ороогүй шит календараар заахад фидер, станц, шитээр эрэмблэгдэж гардаг байх
18. Google Earth програм дээр шинэ суулгасан дэд станц, щитний мэдээлэл монторын гар утсанд байршил заахгүй, ХХХМС програмтай холбогдохгүй байгааг засварлах. Мөн тухайн дэд станц щитний байрлалын google зураг харагддаг болгох
19. ИТА нарын ажлын гүйцэтгэл “Мэдээллийн түүх”-ээр харагддаг болох
20. Хэрэглэгчийн хүсэлтээр түдгэлзүүлсэн ажлын захиалга Гялс дээр хаахад ХХХМС-д давхар хаагддаг болгох. Мөн зөрчлийн улмаас ТҮХ-ээр гүйцэтгүүлсэн түдгэлзүүлсэн хэрэглэгчдэд төлбөрт үйлчилгээний мөнгөн дүнг шивдэг болгох
21. Анхан шатны үзлэгийн зөрчлийн мэдээллүүдийг /UZ 401, 402, 403/ ХХХМС-д шивж оруулдаг /арилгаж болдог/ тайлан гардаг болгох. Тайланд тухайн сараар, нийт үзсэн тоноглолын тоогоор он сар хугацаатайгаа мөн ашиглалтын түвшингийн хувь харагддаг байх, ХҮТ-ийн дүнгээр фидерээр станцаар болон үзүүлэлтийн ангиллаар сонгож тайлагнаж болдог байх./ТЗТ-нар ашиглах/
22. Тоолуурын хайрцагнуудын бүхий л үзлэгийг болон засварын мэдээллүүдийг “ГЯЛС” систем ашиглан бүртгэдэг шууд мэдээллүүд нь онлайн солигддог болгох. Өөрөөр хэлбэл ХХХМС-ийн үзлэг засварын бүртгэлийн цонх “ГЯЛС” системд харагддаг болгох. Мөн бүх тоолуурын хайрцагуудыг индексжүүлэн / QR кодтой болгох/ Үзлэг засварын мэдээллүүдээ бар кодоо /ГЯЛС-аар/ ашиглан бүртгэдэг байх.
23. Холболтын цэгийн мэдээлэлд нэмэлт мэдээллүүд нэмж оруулах /цонх нэмэх/
24. Шинэ холболтын тодруулгын ажлын цэсэнд ажилбар тайлбарын нэмэлт оруулах боломжтой болгох  
Шинэ холболтын ажлын захиалгын товчоо тайланг станцын дугаараар маягтын дагуу шинээр хийх.
25. Өргөдөл гомдол бүртгэдэг хэсэгт ажилбар тайлбарын нэмэлт оруулах боломжтой болгох
26. Төлбөрт үйлчилгээний ажлын ГЯЛС болон ХХХМС-ийн холбоос хэсэгт нэмэлт сайжруулалтуудыг хийх
27. Бүх төрлийн тайлан мэдээллүүд хураангуй болон дэлгэрэнгүй-гээр гардаг байх.
28. Щитний гэрээ цуцалсан хэрэглэгчийн дэлгэрэнгүй болон товчоо тайланг маягтын дагуу шинээр хийх.  
Щитний эрсдлийн үнэлгээний тайланг маягтын дагуу шинээр хийх.  
Щитний хөнгөлөлт эдэлдэг хэрэглэгчдийн болон бусад тайлан гардаг болгох
29. Бүх төрлийн судалгаанууд тайлангаас гарч ирдэг боломжтой болгох. Сонголтоор загваруудыг оруулдаг боломжтой байх.
30. Бүх төрлийн шаардлагатай байдаг лавлагаа мэдээллүүд хардаг боломжтой болгох.  
Энэ тайлан нь фидер дэд станц ХҮТ-ийн дүнгээрээ нэгтгэж сонгож болдог байна.
31. Гэмтэл устгах ажлыг ХХХМС болон ГЯЛС системийг ашиглаж бүрэн бүртгэлжүүлдэг эргээд гүйцэтгэлүүдийг мэдээлэл тайлбар зургийн хамт оруулах боломжтой мөн QR код ашиглан программудын мэдээллүүдийг

дамжуулдаг болгох. Эдгээр ажилбаруудын тайлан шилжилтийн түүхүүд харагддаг байх.

32. Үзлэгийн /анхан болон ээлжит бус мөн АТТогтоох үзлэг/ мэдээллүүдийг бүрэн бүртгэдэг. Ингэхдээ QR код ашиглан бүртгэдэг. Үндсэн үзүүлэлтүүдийг нэмж хасаж болдог боломжтой мөн энд бүртгэсэн мэдээллүүд нь “ГЭМТЭЛ” устгах цэс рүү автоматаар хувиарлагдан очдог байх. QR кодны мэдээллүүд гэмтэлтэй хэсгүүд очдог байх.
33. ХХАТ-аас олон тоолууртай цэгийн залгалтын захиалга авахдаа яг залгах тоолуурын номерыг зөв сонгоогүйгээс тасалсан тоолуур ТҮХ-ийн залгалтаар дахин сэргээгдээд байна. Иймээс ТҮХ-ийн дэд программд Тоолуурын номерыг сонгох боломжтой болгох.
34. Дэд станцаар хэрэглэгчийг хайхад зөвхөн идэвхитэй цэгийн /R1-R6/ / R7 R8 , R 9 , RR / тоо болон бусад гардаг байх.
35. Фидер, дэд станцын мэдэллийг координатын хамтаар экспорт хийх боломжтой байх.
36. Гялс болон ДМСС-н дэд станцын мэдэллийг ХХХМСистемийн фидер, дэд станцтай харьцуулалт хийж засвар хийдэг байх.
37. Бүх программын өөрчлөлт, хадгалалт, засварыг түүх болгон хадгалах.
38. Админ эрхэн дээр Төлбөрт үйцлхилгээний үнэ нэмэх засах цонхтой байх.
39. Зуунмод, Налайх, Зуслан ХҮТ-үүдийн ТТҮХ-ийн монторыг тухайн албан тушаалаар нэг болгож харагдуулах.
40. Түгээхийн мэдээллийн сангийн шинэ УТ системээс фидер, станцын мэдээллийг солилцох боломжтой байх.
41. Google-аар дэвсгэр зургийг УТ системээс авах болон Гялс, ДМСС-тэй адил байх.
42. Программ хангамжийн хөгжүүлэлт дууссаны дараа программын эх кодыг хүлээлгэн өгөх.

## Тоолуурын програм

- ❖ Програмд шинээр хийгдэх болон одоогийн байгаа процессд хийгдэх нэмэлт сайжруулалт өөрчлөлтүүд:
  1. Ажлын байр солигдсон, ажлаас гарсан ажилтны бүртгэлийг идэвхгүй болгох, идэвхтэй байгаа бүх ажилтнуудыг бүртгэлийн дугаарыг өмнө нь дараа нь нэрийг бичиж, дугаараар эрэмбэлэн гаргах, ажилтны нэр нэмж хасах эрхийг мэдээлэл бааз баяжилт хариуцсан инженерт өгөх.
  2. Тоолуурын заалт авах маршрутын хуудас болон тоолуурын заалт оруулах цэсэнд 3 фазын тоолуурын тарифыг өдөр, оргил, шөнө гэсэн дэс дарааллаар гаргах.
  3. Тоолуурын хэсэгт ирж байгаа алдааны кодоор ирсэн захиалгат ажлын гүйцэтгэлийн тайланг маягтаар гаргадаг болгох.
  4. Тоолуурын хэсэгт орж ирж байгаа алдааны кодуудаар хайлт шүүлт хийх эрэмбэлэх боломжтой болгох.
  5. ААН-н тоолуурыг солиход Тоолуурын хэсгээс салгасан заалт орох үед сүүлд бичилт хийгдсэн өдрөөс тухайн өдөр хүртэлх хоосон явалт, чадлын тариф бичилтээ дагаад ордог болгох.
  6. ААН-ийн тоолуур солиход чадлын тариф он сараас хамаарч өндөр орох тохиолдол байдаг тул чадал хэдэн сараар бодогдож байгааг харуулдаг анхааруулга орж ирдэг болгох.
  7. Шинээр тоолуур, гүйдлийн трансформатор бүртгэхэд баталгаажуулалтын тоолуурын бүтцээс хамаарч баталгаажуулалтын огноо шууд автоматаар гардаг болох.
  8. Тоолуурын хөдөлгөөн орж электрон тоолуураар солигдож байгаа, ААН-ээс ахуйн хэрэглэгч рүү шилжиж байгаа хэрэглэгчийн мэдээллийг солиход ахуйн хэрэглэгчийн хөнгөлөлтөнд хамрагдаагүй талаар харагддаг болгох
  9. Тоолуур солисны дараа хэрэглэгчийн түүхээс тоолуурын хөдөлгөөнөөр хайхад тайлбар нь тухайн мэдээлэл оруулсан ажилтны тайлбараар ордог болгох.
  10. Гурван фазын 5А-ын тоолуурыг идэвхгүй төлөвт оруулахад гүйдлийн трансформатор хамт идэвхгүй төлөвт ордог болох.
  11. Хэрэглэгчийн мэдээллийн түүхийн мэдээллийн төрөлд гүйдлийн трансформаторын лацны мэдээлэл харагддаг болгох. Лацны дугаар, дэд станцаар хайлт хийдэг болох.
  12. Хэрэглэгчийн тоолуурын мэдээлэл, хэрэглэгчийн тоолуур солих хэрэглүүр үрүү ороход ахуйн хэрэглэгч, ААН ангилал харагддаг болгох.
  13. Бичилт буцаасны дараа тоолуурын заалтыг хуучин заалтаар үлдээдэг болгох.
  14. Тоолуурын хэсгээс баталгаажилтын үед дундаж хоногийн бичилт орох үед ТУГУБ программд уншдаг болгох, дундаж хоног оруулсан үед бичилт хийгддэг байх.
  15. Шинэ холболтын маягт дээр ТҮХ-ийн тодруулга хийсэн тайлбар харагддаг болох.
  16. Шинэ холболтын захиалга өгсөн боловч хэрэглэгчийн хүсэлтээр хойшлогдсон тохиолдолд хүлээлтийн төлөвт шилжсэн төлөвт оруулж, дараа нь сонгож оруулах төлөвийг шинээр оруулах.

17. Гүйдлийн трансформаторыг бүртгэх явцад марк нь өөр боловч номер ижил бол бүртгэх боломжтой болгох
18. Тоолуурын мэдээллийн түүх дээр гүйдлийн трансформаторын мэдээллийг засахад гүйдлийн трансформаторын бүртгэл мэдээлэл дагаж өөрчлөгддөг болгох.
19. Гүйдлийн трансформаторын бүртгэл тоолуурын бүртгэлтэй ижилхэн болгох.
20. Гүйдлийн трансформаторын дугаараар хайхад станц, цикл, хаяг, тоолуураа дагаж хэлхээний төлөв солигдох /шалтгаан/, утасны дугаар зэрэг харагддаг болгох.
21. ТҮХ-ийн хэсгийн таслалт, залгалт нь хэрэглэгчийн мэдээллийн түүхэнд бүртгэгдэж, харагддаг болох
22. Тоолуурын төлбөрт үйлчилгээний маягт дээр циклийн дугаар, станцын щитны дугаар харагддаг болгох.
23. Тоолуурын марк нэмэх болон идэвхгүй болгох цэстэй байх.

❖ Шинээр хийгдэх болон одоогийн байгаа тайлан болон процедурд нэмэлт сайжруулалт өөрчлөлтүүд:

1. Тоолуурын мэдээллийн түүхтэй болох.
2. Программ дээр гарах боломжтой тайлангууд үнэн зөв гардаг болгох  
Хэрэглэгчийн зөрчлийн мэдээлэл Маягт Т-8 тайланг өөрчлөх.  
Тоолуурын хөдөлгөөний тайланг өөрчлөх. Маягт Т-3  
Гүйдлийн трансформаторыг баталгаажуулалтанд хамруулах төлөвлөгөөний тайланг хийх. Маягт Т-7  
Төлбөрт үйлчилгээний захиалгат ажлын дэлгэрэнгүй болон товчоо тайланг маягтын дагуу шинээр хийх. Маягт Т-19 а,б гэх мэт...
3. Тоолуурын эзэмшлийн тайланг тоолуурын төрөл болон хэрэглэгчийн ангилалаар дэлгэрэнгүй болон товчоо байдлаар маягтын дагуу шинээр хийх.
4. Тоолуурыг хүчдлийн түвшин хэрэглэгчийн ангилал, тоолуурын төрлөөр харуулсан тайланг дэлгэрэнгүй болон товчоо байдлаар маягтын дагуу шинээр хийх.
5. Тоолуур солилтоор салгасан тоолуурын кВт-ын бичилт болон задгай дундаж кВт-ын тайланг маягтын дагуу шинээр хийх.
6. Шинээр тоолуур, гүйдлийн трансформатор баталгаажуулсан тайланг маягтын дагуу шинээр хийх. Энэ нь Тухайн сард болон өдрөөр баталгаажуулсан тоолуур гүйдлийн трансформаторын дэлгэрэнгүй болон товчоо тайлан
7. Захиалгат ажлын захиалгат ажлын дундаж хугацааг гүйцэтгэсэн ажлын тайланг дэлгэрэнгүй болон товчоо байдлаар маягтын дагуу шинээр гаргах
8. Мэдээллийн баазын буруу үзүүлэлтүүдийн тайланг дэлгэрэнгүй болон товчоо байдлаар маягтын дагуу шинээр хийх
9. Бүх тоолуурын төрөл, фазын ангилал маркийг тоо ширхэгээр харуулсан дэлгэрэнгүй болон товчоо тайланг динамик байдлаар маягтын дагуу шинээр хийх.
10. Гүйдлийн трансформаторын марк болон коэффициентийг тоо ширхэгээр харуулсан тайланг дэлгэрэнгүй болон товчоо байдлаар маягтын дагуу шинээр хийх.

11. Лацны мэдээллийн түүхтэй болох. ХҮТ-үүд агуулахаас лац аваад программд лацны дугааруудыг оруулж, монёрууд лац ашиглахаар авах тохиолдолд программ дээр нэг бүрчлэн бүртгэх.
12. Ашигласан лац, болон ашиглаагүй үлдсэн, ашиглаад солигдсон лацны тайланг маягтын дагуу шинээр хийх.
13. Баталгааны хугацаа дуусаагүй тоолуурыг баталгаажуулах болон солисон тайлан гардаг болгох.
14. Бүх программын өөрчлөлт, хадгалалт, засварыг түүх болгон хадгалах.

## Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

### Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

#### Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

#### Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

#### Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

*Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.*



Долоо. **ЖИШИГ МАЯГТ**  
ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                        | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                       | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгааар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгааар төлөвлөсөн өдөр дуусгана.   |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                   | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| <b>5. Зааварчилгаа</b>                                     | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                             | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## **Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**

- |                                     |   |
|-------------------------------------|---|
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>            | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b> | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.  |

9. **Зөрчил, гологдол арилгах**
- 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.  
**Чанарын баталгаат хугацаа 12 сар байна.**
- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
10. **Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

11. **Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
12. **Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
13. **Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

14. **Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15. **Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. **Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.

Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай

нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

## **20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <b>ХХХМС-2 программын дэд баазын бүртгэлд өөрчлөлт, шинэчлэлт хийх ба гялс системтэй холбох ажил ХА-010/2020</b>
ГЕН 2.1	Ажил нь: УБЦТС ХК-ийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй Хэрэглэгчтэй Харилцах Харилцааны Менежментийн Системийн нэмэлт сайжруулалт, хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэх.  Ажлын талбай нь <b>УБЦТС ТӨХК</b> -д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь [С.Доржбал МТА-ны инженер]
ГЕН 4.1	Гэрээт ажлын нийт хугацаа: 100 хоног  Ажил эхлэх өдөр: Гэрээний дагуу  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: Гэрээ байгуулсанаас хойш хуанлийн 100 хоногт
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [14] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа: 12 сар байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [0,1 хувь] байна. <sup>4</sup>  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [10 хувь] байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээнд заасан хугацаанд гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг гэрээнд заасан хугацаанд гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [10 хувь] байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [10 хувь]-иар тооцно.

<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

<sup>4</sup> Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

\_\_\_\_\_

(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_

(Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Гарын үсэг)

\_\_\_\_\_

(Албан тушаал)

\_\_\_\_\_

(Албан тушаал)

***[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.***

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг

үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/  
Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.



ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]\_\_\_\_\_

[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

---